



IV/2022


Тархаасан: 2022 оны 5 дугаар сарын 15



Үнэмлэхүй их температур 2022 оны 4 дүгээр сард Баянхонгор аймгийн Шинэжинст суманд 29.0°C-д хүрсэн байна

Агаарын үнэмлэхүй их температур 2022 оны 4 дүгээр сард Баянхонгор аймгийн Шинэжинст суманд 29.0°C, үнэмлэхүй бага температур Баян-Өлгий аймгийн Сагсай суманд -22.0°C-д хүрлээ.

ЗУРАГ 1. АГААРЫН ТЕМПЕРАТУР (°C), олон жилийн дундажтай¹ харьцуулснаар, станцын байршлаар, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар



¹ - Сүүлийн 30 жил

Цаг уур, орчны шинжилгээний газрын мэдээгээр 2022 оны 4 дүгээр сард орсон хамгийн их хур тунадасны нийлбэр хэмжээ Баянхонгор аймгийн Баянхонгор суманд 27.3 мм-т хүрсэн байна. Үнэмлэхүй их салхины хурд Баян-Өлгий аймгийн Өлгий, Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын нутгаар 30 м/с-д хүрсэн байна.

Агаарын чанар


Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн сарын хамгийн их агууламж 2022 оны 4 дүгээр сард Баруун дөрвөн зам, Таван буудал, Баянхошуу, Хайлааст, Амгалан, Мишээл экспо төв, Зурагт, Тахилт орчимд 0.051 мг/м³-0.263 мг/м³-д хүрч, агаарын чанарын хүлцэх агууламжаас 0.001 мг/м³-0.213 мг/м³-ээр буюу 2.0 хувиас 5.3 дахин давсан байна.

Азотын давхар ислийн сарын хамгийн их агууламж 2022 оны 4 дүгээр сард Богд хааны ордон музей, Цахилгаан станц, 13-р хороолол, Амгалан, Тахилт, Баруун дөрвөн зам орчимд 0.055 мг/м³-0.091 мг/м³-д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.005 мг/м³-0.041 мг/м³-ээр буюу 10.0-82.0 хувиар давсан байна.

Харин PM 10 тоосонцрын сарын хамгийн их агууламж 2022 оны 4 дүгээр сард Хайлааст, Таван буудал, Мишээл экспо төв, Тахилт, Ургах наран хороолол, Богд хааны ордон музей, Баруун дөрвөн зам, 13-р хороолол, Зуун айл, Цахилгаан станц, Баянхошуу орчимд $0.141 \text{ мг/м}^3 - 0.684 \text{ мг/м}^3$ -д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас $0.041 \text{ мг/м}^3 - 0.584 \text{ мг/м}^3$ -ээр буюу 41.0 хувиас 6.8 дахин давсан байна.

Улаанбаатар хотын агаар дахь PM 2.5 тоосонцрын дундаж агууламж 2022 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 0.009 мг/м^3 (56.7%)-ээр, азотын давхар ислийн дундаж агууламж 0.015 мг/м^3 (59.5%)-ээр, хүхэрлэг хийн дундаж агууламж 0.013 мг/м^3 (35.2%)-ээр, PM 10 тоосонцрын дундаж агууламж 0.025 мг/м^3 (38.9%)-ээр тус тус их байна.

ЗУРАГ 2. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАГЧ БОДИСУУДЫН САРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар, мг/м^3



Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол 2022 оны эхний 4 сарын байдлаар 1497 болж, өмнөх оны мөн үеэс 32 (2.2%) -оор өссөн байна. Газар хөдлөлт 2022 оны эхний 4 сарын байдлаар 23 удаа бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 197 (89.5%) -гоор буурсан байна.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2022 оны эхний 4 сарын байдлаар нийт 42 хүн амь насаа алдаж, өмнөх оны мөн 36 (46.2%) -гаар буурсан байна.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2022 оны эхний 4 сарын байдлаар 7.1 тэрбум төгрөгийн хохирол учирч, 2.0 тэрбум төгрөг зарцуулсан байна.

ХҮСНЭГТ 1. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ², жил бүрийн эхний 4 сарын байдлаар

Үзүүлэлт	2019 I-IV	2020 I-IV	2021 I-IV	2022 I-IV	<u>2022 I-IV</u>
					<u>2021 I-IV</u>
					хувь
Аюулт үзэгдэл, ослын тохиолдол	2 074	1 724	1 465	1 497	102.2
Газар хөдлөлтийн тохиолдлын тоо	11	28	220	23	10.5
Объектын түймрийн тоо	1 817	1381	987	1 182	119.8
Амь насаа алдсан хүний тоо	49	59	78	42	53.8
Учирсан хохирол, тэрбум төгрөг	4.2	91.3	7.9	7.1	89.9
Зарцуулсан зардал, тэрбум төгрөг	0.5	0.1	0.5	2.0	3.9 ¹

² - Корона вируст халдварын тохиолдлын тоо болон түүнтэй холбоотой гарсан зардлыг оруулаагүй.

Ойлголт, тодорхойлолт

Агаарын бохирдол: Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

Аюулт үзэгдэл: Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

Гамшиг: Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно.

Зөвшөөрөгдөх түвшин: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

Хүлцэх агууламж: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.



Эх үүсвэр:

Цаг уур, орчны шинжилгээний газар;
Онцгой байдлын ерөнхий газар;

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 6 дугаар сарын 13

Эдийн засгийн статистикийн
газрын дарга А.Дэмбэрэл
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн
газрын ахлах статистикч Б.Уянгаа
Утас : (976-51)-261563



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212